/162./ 18 сартай хүүхдийн гүйцэд хийх хөдөлгөөнийг нэрлэнэ үү.

- A. 1 хөл дээр зогсож, 3 дугуйт унаж чадна
- B. Гүйнэ, шатаар алхана, өөрөө хооллоно
- C. Мөлхөнө, юм түшээд зогсоно
- D. Хүний гараас бариад алхаж явна
- E. Үсэрч харайна, 1 хөл дээр 10 секунд зогсоно

/163./ Аутизмтай хүүхдийн хэдэн хувьд мэдэрхүйн шинж илэрдэг вэ?

- A. 94%
- B. 85%
- C. 55%
- D. 69%
- E. 45%

/164./ Хүүхэд хэдэн сартайгаас толгойгоо дааж эхлэх вэ?

- A. 4 сар
- B. 2 сар
- C. 3 сар
- D. 5 сар
- E. 6 сар

/165./ AD(H)D-тэй хүүхдийн суралцах чадварыг сайжруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ?

- A. Тогтмол хичээллэх
- B. Тогтвортой суух
- C. Цагаан хана, дуу чимээ ашиглах
- D. Анхаарал сарниулах зүйлсийг холдуулах
- E. Цагийн менежмент хийх

/166./ Хүүхдийн биеийн жинг олдог томъёог настай харгалзуулна уу?

- 3-12 сар A. Биеийн жин=(Нас (сар))/2+9
- 1-6 нас B. Биеийн жин="Нас " ("жил")"7+8" /2
- 7-12 нас C. Биеийн жин = Нас (жил) 2+8

- A. 1A ,2C, 3B
- B. 1C ,2A, 3B
- C. 1B ,2C, 3A
- D. 1A ,2B, 3C
- E. 1C ,2B, 3A

/167./ 8. Цусны сахар багасалт яагаад үүсдэг вэ?

- A. Инсулины хэмжээ бага байснаас
- B. Эхний 3 хоногт сайн хөхөөгүйгээс
- C. Жин бага төрснөөс
- D. Бор өөх их бий болсноос
- E. Физиологийн онцлог учраас

/168./ Хүүхдийн атгах рефлексийн шинжийг нэрлэнэ үү.

- A. Амаа ангайж, цочруулын зүг эргэнэ
- B. Алганд хүрэхэд, хурууг нугалж, атгана
- C. Толгой бөхийхөд гар нугарч, хөл тэнийнэ, гэдийлгэхэд хөл нугарч, гар тэнийнэ
- D. Нүүр харсан талын гар хөл тэнийж, эсрэг талын гар хөл нугална
- E. Мөрөөр холдуулж, тохой хурууг тэнийлгэнэ

/169./ Тархины саажлын шалтгаанд аль нь орохгүй вэ?

- A. TORCH халдвар
- B. 2 нас хүртэлх гэмтэл
- C. 2 нас хүртэлх тархины халдвар

D. Өөх тосны солилцооны давшингуй явцтай эмгэг

E. Удамшиллын шалтгаан

/170./ Ханьг цайвар өнгөтэй байлгадаг шалтгаан юу вэ?

A. Тайвшруулах

B. Анхаарал төвлөрүүлэх

C. Эмчлэх

D. Таатай орчин бүрдүүлэх

E. Хараа сайжруулах

/171./ Дээрх тохиолдолд ширээн дээр суух байрлалуудаас аль нь гарны үйл ажиллагаанд илүү нөлөөлдөг байрлал аль нь вэ?

A. Зориулалтын суулгах ширээ сандал хэрэглэх

B. Өвдгөөр нугалан зогсоож ширээ түшүүлэх

C. Золгуулагч ашиглан зогсоох

D. Хөлөнд чиг хийн шалан дээр хөлийг жийлгэх, жижиг ширээ түших, гараа ширээн дээр тавих

E. Шалан дээр хөлийг жийлгэх, жижиг ширээ түших, гараа ширээн дээр тавих

/172./ Харгалзуул

1. Нярай нас

A. 1-3 нас

2. Нялх нас

B. 30-365 хоног

3. Балчир нас

C. 4-7 нас

4. Торних нас

D. 0-29 хоног

5. Хүүхэд нас

E. 8-12

A. 1D ,2B, 3E, 4A, 5C

B. 1D ,2B, 3A, 4C, 5E

C. 1D ,2B, 3A, 4E, 5C

D. 1 B ,2D, 3A, 4C, 5E

E. 1 A ,2B, 3D, 4C, 5E

/173./ Эрик Эриксоны ангиллаар хүүхэд хэдэн сартайдаа бүх юмсыг амаараа мэдэрдэг вэ?

A. 1-3 сар

B. 3-4 сар

C. 4-6 сар

D. 2-4 сар

E. 2-5 сар

/174./ Аль нь Дауны хам шинжийг зөв ойлголт вэ?

A. Олон тооны трисомуд 21 дараагийн байрлалд шилжсэн

B. Хожуу насанд төрж байгаа хүүхдүүд

C. Хэл ярианы эмгэг өөрчлөлт асуудалгүй

D. булчингийн тон их

E. Ихэвчлэн хөвгүүдэд тохиолдоно

/175./ Ширээ налуу байх нь ямар давуу талтай вэ?

A. Биед эвтэйхэн

B. Харааны талбайг нэмэгдүүлнэ

C. Бичихэд саадгүй

D. Харааны талбайг багасгана

E. Гар зөв байрлана

/176./ Тархины саажилттай хүүхдийн алхааны зогсоо байрлалд (stance phase) түнхний тэнийлгэх хөдөлгөөн буурах нь ямар нөлөөллийг үүсгэх вэ?

1. Түнхний ойртуулах хэлбэрийн контрактур үүсгэх

2. Түнхний нугалах хэлбэрийн контрактур үүсгэх

3. Өвдөгний нугалах хөдөлгөөнийг бууруулах

4. Өвдөгний тэнийлгэх хөдөлгөөнийг бууруулах

5. Түнхний тэнийлгэх хэлбэрийн контрактур үүсгэх

/177./ 10-11 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?

1. Ухрах болон хажуу тийш алхах

2. Богино хугацаанд бусдын дэмжлэггүйгээр зогсох

3. Бусдын дэмжлэггүйгээр алхах
4. Алган дээр тулж мөлхөх
5. Суугаа байрлалаас бөмбөг шидэх

/178./ Умай дахь амьдралын үеийн 16 долоо хоногт бүрэлдэн бий болох эрхтэн тогтолцоог сонгоно уу?

1. Дээд мөч
2. Мэдрэл
3. Доод мөч
4. Оюун ухаан
5. Зүрх

/179./ Умайн гаднах амьдралыг юу гэж ангилдаг вэ?

1. Нярай үе
2. Эрт нялзрай үе
3. Торних үе
4. Хожуу нярай үе
5. Нялзрай үе

/180./ Аутизмтай хүүхдийн бие махбодын үйл ажиллагааг зохицуулахын тулд ямар үйлдлүүдийг хийлгэх хэрэгтэй вэ?

1. Унших
2. Хайчлах
3. Өөрөө хувцаслах
4. Зурах
5. Дуулах

/181./ AD(H)D-тэй хүүхдийн хараа сонсголын нөлөөллийг багасгахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?

1. Дуу чимээг бууруулах
2. Харагдах талбарыг хязгаарлах
3. Ханыг цайвар өнгөөр будах
4. Үйл ажиллагааг сайжруулах
5. Бусадтай ярилцах

/182./ Шууны сарвууг нугалагч (flexor carpi radialis) булчингийн мэдрэлжүүлэлтийг сонгоно уу.

- A. C6,7
- B. C8
- C. C4,5
- D. T1
- E. T2,3

/183./ Далны маяа эгэмний үений хаалттай байрлал хэдэн градусын мөрний холдуулах хөдөлгөөний үед үүсэх вэ?

- A. 60
- B. 70
- C. 80
- D. 90
- E. 100

/184./ 43. Дараах тохирох хөдөлгөөнүүдийг уялдуулна уу

- A. Тохойн үеэр 90 градус нугалсан байдлаас тэнийлгэх
- B. Тохойн үеэр 90 градус нугалсан байдлаас гарын алгыг доош харуулахын тулд шуугаар эргүүлэх хөдөлгөөн
- C. Биеэс мөр гадагшлуулах хүртэлхи хөдөлгөөн
- D. Хөлийн хуруун дээр зогсох хөдөлгөөн
- E. Биеэс мөр урагшлуулах хөдөлгөөн

1. Тэнийлгэх (extension)
2. Пронаци (pronation)
3. Холдуулах (abduction)
4. Жийх (ankle planter flexion)
5. Нугалах (flexion)

- A. A5 B4 C3 D2 E1
- B. A4 B5 C1 D2 E3
- C. A3 B2 C1 D4 E5
- D. A2 B1 C5 D4 E3
- E. A1 B2 C3 D4 E5

/185./ Настай холбоотойгоор аль булчингийн хүч хамгийн ихээр алдагдах вэ?

- A. Нугалах
- B. Тэнийлгэх
- C. Гадагш эргүүлэх
- D. Дотогш эргүүлэх
- E. Супинаци

/186./ Богтос бугалга ясны үенд ямар хөдөлгөөний улмаас хаалттай байрлал үүсэх вэ?

- A. Тэнийлгэх
- B. Нугалах
- C. Пронаци
- D. Супинаци
- E. Татагдах хөдөлгөөн

/187./ Хугарлын дараагаар гиспстэй үед тухайн булчинг хатигаршуулахгүйн тулд хийгдэх дасгал?

- A. Изокинетик
- B. Изометрик
- C. Изотоник
- D. Координаци
- E. Концентрик агшилт

/188./ Дараах булчингийн гүйцэтгэх үүргийг харгалзуулна уу.

- A. Трапец булчингийн дээд салаа
 - B. Далны доорх булчин
 - C. Жижиг бөөрөнхий (teres minor) булчин
 - D. Хонин сүүлт булчингийн дунд салаа
 - E. Трапец булчингийн доод салаа
1. Мөрний үеэр гадагш эргүүлэгч
 2. Дал дээш өргөх
 3. Мөрний үеэр дотогш эргүүлэгч
 4. Мөрний үеэр холдуулагч
 5. Дал буулгах

- A. A1 B2 C3 D5 E4
- B. A2 B3 C1 D4 E5
- C. A3 B4 C5 D2 E1
- D. A4 B5 C2 D1 E3
- E. A5 B1 C4 D3 E2

/189./ Булчингийн тонус юуны дүнд үүсэх вэ?

- A. Үений нугалах хөдөлгөөн
- B. Үений холдуулах хөдөлгөөн
- C. Сунгах рефлекс
- D. Изотоник агшилт
- E. Үений тэнийлгэх хөдөлгөөн

/190./ Дараах үенүүдээс аль нь биеийг сулласан үед 10 градусын супинацийг хийх вэ?

- A. Проксимал шуу богтос
- B. Шуу бугалга
- C. Дистал шуу богтос
- D. Алга яс шуу
- E. Алга яс богтос

/191./ Дараах булчингийн гүйцэтгэх үүргийг харгалзуулна уу.

- A. Хонин сүүлт булчингийн урд салаа (anterior deltoid)
- B. Хонин сүүлт булчингийн дунд салаа (middle deltoid)

C. Хонин сүүлт булчингийн хойд салаа (posterior deltoid)

D. Далны хуудас булчин (subscapularis)

E. Жижиг бөөрөнхий (teres minor) булчин

1. Мөрний үеэр гадагш эргүүлэгч

2. Мөрний үеэр дотогш эргүүлэгч

3. Мөрний үеэр тэнийлгэгч

4. Мөрний үеэр холдуулагч

5. Мөрний үеэр нугалагч

A. A2 B1 C5 D4 E3

B. A3 B2 C4 D5 E1

C. A4 B3 C2 D1 E5

D. A5 B4 C3 D2 E1

E. A1 B5 C3 D2 E4

/192./ Хөлдүү мөрний шинж бүхий өвчтөнд юуны түрүүнд ямар хөдөлгөөний далайцыг сэргээх вэ?

A. Мөрний үеэр холдуулах

B. Мөрний үеэр ойртуулах

C. Мөрний үеэр гадагш эргүүлэх

D. Мөрний үеэр тэнийлгэх

E. Мөрний үеэр дотогш эргүүлэх

/193./ Дал бугалганы хэмнэлийн харьцааг сонгоно уу.

A. 1:2

B. 1:3

C. 2:1

D. 3:1

E. 4:1

/194./ Хүзүүний муруйлтын (wry neck) шалтгаан аль нь вэ?

A. Хөхлөг сэртэн эгэм хооронд холбосон булчингийн чангарал

B. Хөхлөг сэртэн эгэм хооронд холбосон булчингийн сулрал

C. Трапец булчингийн доод дунд салааны чангарал

D. Трапец булчингийн дээд салааны чангарал

E. Трапец булчингийн дээд салааны сулрал

/195./ Бугалга ясны том төвгөр нь хаана тэмтрэгдэх вэ?

A. Акромион сэртэнгийн гадна гадаргуугаас доошлоход

B. Акромион сэртэнгийн хойд гадаргуугаас доошлоход

C. Акромион сэртэнгийн урд гадаргуугаас доошлоход

D. Эгэмний бугалга ясны холбоосын хэсэгт

E. Эвэр хошуу сэртэнгийн гадна гадаргууд

/196./ Дараах булчингийн эхлэл, төгсгөлийг уялдуулна уу

A. Бөөрөнхий том (teres major) булчингийн эхлэл

B. Бөөрөнхий жижиг (teres minor) төгсгөл

C. Далны хуудас (subscapularis) булчингийн эхлэл

D. Далны хамрын доод (infraspinatus) булчингийн эхлэл

E. Далны хамрын дээд (supraspinatus) булчингийн эхлэл

1. Бугалга ясны том төвгөр

2. Далны доод өнцөг орчим

3. Далны хавирга талын гадаргуу

4. Хамрын дээд хонхор

5. Хамрын доод хонхор

A. A1 B2 C3 D4 E5

B. A2 B3 C4 D5 E1

C. A3 B4 C5 D1 E2

D. A1 B2 C3 D5 E4

E. A5 B4 C1 D2 E3

/197./ Тархины саажилттай хүүхдийн тавхай унжих шалтгаан аль нь вэ?

- A. Гуяны арын булчингийн чангарал
- B. Гуяны урд булчингийн чангарал
- C. Шилбэний эрээн булчингийн чангарал
- D. Шилбэний эрээн булчингийн сулрал
- E. Шилбэний эрээн булчингийн богиносолт

/198./ Өвчтөн гравитацийн хүч болон бага эсэргүүцлийн эсрэг бүтэн үений далайцаар хөдөлгөөн хийгдэж байвал булчингийн хүчийг үнэлэх сорилоор хэдэн оноо вэ?

- A. 1
- B. 2
- C. +2
- D. 3
- E. +3*

/199./ Өвчний цочмог үед аль эмчилгээний дасгалаар эхлэх вэ?

- A. Идэвхтэй
- B. Хагас идэвхтэй
- C. Идэвхгүй
- D. Хүч хөгжүүлэх
- E. Биеийн жинг авахуулах

/200./ Цус харвалтын дараагаар өвчтөний дээд мөчинд үүссэн нугалах хэлбэрийн синергитик чангаралыг хэрхэн суллах вэ?

- A. Дистал хэсгээс нугалах
- B. Дистал хэсгээс тэнийлгэх
- C. Проксимал хэсгээс нугалах
- D. Проксимал хэсгээс тэнийлгэх
- E. Дистал хэсгээс пронаци хийх

/201./ Мобилизаци нь ямар хөдөлгөөнд хамаарах вэ?

- A. Идэвхтэй
- B. Хагас идэвхтэй
- C. Идэвхгүй
- D. Хагас идэвхгүй
- E. Координаци

/202./ Булчингийн уртын хэмжээ ихсэж хийгдэх агшилтыг сонгоно уу.

- A. Концентрик
- B. Экцентрик
- C. Изометрик
- D. Изотоник
- E. Изокинетик

/203./ Дараах хүзүүний булчингийн агшилтын хэлбэрийг харгалзах байрлалд нь уялдуулна уу

- A. Тэнийлгэгч булчингууд 2 талд уртсаж агших
- B. Нугалагч булчингууд 2 талд богиносож агших
- C. Нугалагч булчингууд уртсаж агснаар тэнийлгэгч булчингууд богиносож агших
- D. Тэнийлгэгч булчингууд 2 талд богинож агших
- E. Эсрэг үйлдэлтэй нугалагч, тэнийлгэгч булчингууд уртсаж агших

1. Суугаа байрлалд хүзүү нугалах
2. Дээшээ харж хэвтсэн байрлалд хүзүү нугалах
3. Суугаа байрлалд хүзүү тэнийлгэх
4. Доошоо харсан байрлалаас хүзүү тэнийлгэх
5. Суугаа байрлалд хүзүү хажуу тал руу нугалах

- A. A1 B5 C4 D3 E2
- B. A4 B5 C3 D2 E1
- C. A5 B4 C3 D2 E1
- D. A1 B2 C3 D4 E5
- E. A4 B5 C1 D3 E5

/204./ Тохойн үений гэмтлийн дараагаар ихэнх өвчтөнүүд тохойгоор нугалах хэлбэртэй байх шалтгаан юу вэ?

- A. Тохойн үенд ирэх даралт бага байдаг
- B. Үений зай ихэсдэг
- C. Лигаментийн татагдал бага байдаг
- D. Үений капсулын чангарал бага байдаг
- E. Үений зайг бууруулдаг

/205./ Хөдөлгөөн засалч нь эмчилгээний зорилгыг ICF-н аль хэсэгт тулгуурлан гаргах вэ?

- A. Идэвхи
- B. Бүтэц
- C. Орчны хүчин зүйл
- D. Оролцоо
- E. Хувь хүний хүчин зүйл

/206./ Бугалга ясны делтойд (deltoid) төвгөр нь хаана тэмтрэгдэх вэ?

- A. Бугалга ясны дотоод гадаргуу, уртын 1/2 хэсэгт
- B. Бугалга ясны гадаад гадаргуу, уртын 1/2 хэсэгт
- C. Бугалга ясны урд гадаргуу, уртын 1/2 хэсэгт
- D. Бугалга ясны хойд гадаргуу, уртын 1/2 хэсэгт
- E. Бугалга ясны уртын 1/2 хэсэгт

/207./ Тохойн үеэр 90 хэм нугалахад m.biceps brachii агших учраас антогност булчин M. triceps brachii суларна.

/208./ Синергитик хөдөлгөөн нь мэдрэлийн эмгэгийн үед үүсэх учраас дээд мөчний нугалах хэлбэрийн синергитик хөдөлгөөний үед мөрөөр ойртуулах хөдөлгөөн хийгддэг.

/209./ Хүзүүгээр зүүн тийш эргүүлэх хөдөлгөөн хийхэд баруун талын m.sternocleidomastoid агших учраас баруун тийш эргүүлэхэд баруун талын m.sternocleidomastoid агшихгүй.

/210./ Аливаа эмгэгийн үед булчингийн хүчний дасгалыг изометрик хэлбэрийн дасгалаар эхлэх учраас изометрик дасгалын үед булчингийн урт өөрчлөгддөг.

/211./ Бугуйн үеэр тэнийлгэх хөдөлгөөн хийхэд m.Extensor radialis агших учраас гарыг атгаж суллахад m.flexor radialis агшдаг.

/212./ Дээд мөчний протезын ангиллыг тохируулна уу.

- 1. Механик бугуйн протез
- 2. Цахилгаан бугуйн протез
- 3. Биеийн хүчний тохойн протез
- 4. Гадагш эргэлттэй тохойн протез
- 5. Хөдөлгөөний идэвхгүй тохойн протез
- A. Нугалах хэлбэрийн
- B. Асаах унтраах хяналтат хэлбэрийн
- C. Гадагш эргэсэн, нугалах хэлбэрийн дэмжлэгтэй
- D. Гар аргаар түгжигддэг
- E. Тоон системтэй асаах унтраах хяналтат

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A1 B2 C3 E4 D5
- C. A1 B2 E3 D4 C5
- D. A1 C2 B3 E4 D5
- E. A1 E2 D3 B4 C5

/213./ Өрцний үйл ажиллагааг сегментийн аль түвшин хариуцах вэ?

- A. C6
- B. C1
- C. C3,C4,C5

D. C5

E. C7

/214./ Чихрийн шижингийн улмаас доод мөч тайруулсан үйлчлүүлэгчид хөдөлмөр засалч ямар үйлчилгээ үзүүлэх вэ?

A. Усанд ороход нь тусална

B. Бие засахад нь тусална

C. Гадуур гарахад нь тэргэнцрээр үйлчилнэ

D. Их бие, дээд мөчдийн дасгал хөдөлгөөн хийлгэнэ

E. Амьдралын чанарт нөлөөлөх хүчин зүйлсэд үнэлгээ өгнө

/215./ Цус харвалтын улмаас дээд мөчинд үүссэн нугалах хэлбэрийн нийлмэл хөдөлгөөний үед далны үеэр хийгдэх хөдөлгөөнийг сонгоно уу.

A. Гадагш эргүүлэх

B. Абдукци

C. Доош шилжих

D. Дээш шилжих

E. Дотогш эргүүлэх

/216./ Brunnstrom Stage 3-р шатыг сонгоно уу.

A. Нийлмэл хөдөлгөөний хэлбэр алдагдаж, салангид хөдөлгөөн хийх боломжтой

B. Зориудын нийлмэл хөдөлгөөн хийх боломжтой

C. Зориудын хөдөлгөөн ажиглагдахгүй. Булчин сулралтай

D. Чангарал буурч салангид хөдөлгөөнийг хийх боломжтой

E. Зоиудын нийлмэл хөдөлгөөн хийх боломжгүй

/217./ GMFCS IV түвшинд байгаа тархины саажилттай 2-4 насны хүүхдийн хийж чадах үйлдлийг сонгоно уу?

A. Тогтвортой сууж чадна

B. Мөлхөж чадна

C. Зогсож чадна

D. Сууж чадах боловч тэнвэр муутай

E. Алхаж чадна

/218./ Чихрийн шижин өвчний хэв шинж-2 –ын онцлог юу вэ?

A. Вирусын болон аутоиммуны шалтгаанаар нойр булчирхайн бета эсийн гэмтэл үүсч инсулины туйлын дутагдалд хүргэдэг эмгэг юм.

B. Дотоод шүүрлийн болон бусад шалтгааны улмаас хоёрдогч буюу шинж тэмдгийн байдлаар илэрдэг чихрийн шижинг хэлнэ.

C. Инсулины шүүрэл багасах болон инсулин дааврын үйлдэл алдагдсанаас цусан дахь глюкозын хэмжээ ихэсч улмаар их уух, их шээх хам шинжээр илэрдэг бодисын солилцооны эмгэг юм.

D. Удамшлын болон амьдралын буруу хэв маягаас шалтгаалан инсулины шүүрлийн алдагдал болж улмаар инсулины харьцангуй дутагдалд хүргэдэг эмгэг юм.

E. Цусны глюкозын хэмжээ ихсэх,артерийн даралт ихсэлт, цусан дахь өөх тосны харьцаа алдагдах зэрэг хам шинжүүдээр илрэх бодисын солилцооны эмгэг юм.

/219./ Дараах нурууны өвдөлтийн дерматомын байрлалыг тохируулна уу.

1. Нуруу, дунд чөмөгний толгой, цавь орчим

2. Нуруу, гуяны урд талаар өвдөг хүртэл

3. Өгзөг, гуяны араар, шилбэ орчим

4. Нуруу, өгзөгний дээд хэсэг, гуяны урдуур, шилбэний дотор тал

5. Цавь, гуяны дотор талаар өвдөг хүртэл

A. L1

B. L2

C. L3

D. S1

E. S3

A. A1 B2 C3 D4 E5

B. A1 C2 B3 E4 D5

C. A1 B2 D3 C4 E5

D. A1 C2 D3 E4 B5

E. A1 B2 E3 D4 C5

/220./ Монгол хүмүүсийн насны ангиллыг харгалзуулна уу

A. Хижээл нас 1. 61-72 нас

B. Өтөл нас 2. 25-36 нас

C. Залуу нас 3. 13-24 нас

D. Өсвөр нас 4. 37-48 нас

E. Идэр нас 5. 49-60 нас

A. A4, B1, C3, D2, E5

B. A5, B1, C2, D3, E4

C. A5, B1, C3, D2, E4

D. A1, B5, C3, D2, E4

E. A5, B1, C4, D3, E2

/221./ Өлөн үед цусан дахь глюкозын хэвийн хэмжээ хэд байдаг вэ?

A. < 5.6 ммоль/л

B. 5.6-6.0 ммоль/л

C. 6.1-7.8 ммоль/л

D. 7.8-11.0 ммоль/л

E. \geq 11.1 ммоль/л

/222./ 57 настай эрэгтэй, таламусын хэсэгт цус алдалтын харвалт өгсөн. Үзлэгээр өнгөц болон гүний мэдрэхүй алдагдагдсан. Хөдөлгөөний саажилт илрээгүй. Доорх хариултуудаас аль нь үйлчлүүлэгчид өгөх буруу мэдээлэл вэ?

A. Нүдээ нээлттэй тэнцвэрийн дасгал

B. Дасгал хөдөлгөөнийг удаанаар алгуур хийх

C. Дасгалын нэг удаа хийхдээ 15 минутаас ихгүй, цөөн тоогоор хийх

D. Саатай талын гарны хөдөлгөөнийг тусгаарлах хэрэгслээр хамгаалах

E. Бичих дасгал хийж байх үед бичгийн хэрэгсэл болон бичгийн хэвний хоорондын хамаарлыг ажиглана

/223./ Аль нь тархмал хатуурлын зөв хариулт вэ?

A. Ихэвчлэн эрэгтэйчүүд

B. Эргэн сэдэрдэг

C. Биед гэмтэл үүсгэдэг.

D. 60 орчим насанд ихэвчлэн илэрнэ

E. Ухтофийн шинж ажиглагдана

/224./ GMFCS IV түвшинд байгаа тархины саажилттай 2-4 насны хүүхдийн хийж чадах үйлдлийг сонгоно уу

A. Тогтвортой сууж чадна

B. Мөлхөж чадна

C. Сууж чадах боловч тэнвэр муутай

D. Зогсож чадна

E. Удаан хугацаанд зогсож чадна

/225./ Өвдөгний остеоартритын үеийн хөдөлгөөн засал эмчилгээний зэргийг нотолгооны түвшинтэй харьцуулан тохируулна уу.

1. Жингээ хаях эмчилгээ

2. Координацийн дасгал

3. Ортез эмчилгээ

4. Сунгалтын дасгал, үений далайцын дасгал

5. Хагалгааны дараах урт хугацааны эмчилгээ

A. A1

B. A2

C. B1

D. C2

E. D1

A. 1A 2C 3B 4E 5D

- B. 1A 2B 3C 4D 5E
- C. 1A 2B 3E 4C 5D
- D. 1A 2E 3B 4D 5C
- E. 1A 2C 3D 4B 5E

/226./ Мөрний бэхэлгээтэй, шууны арын бэхэлгээтэй чигийг хэрэглэхэд аль нь тохиромжтой вэ?

- A. Шууны арын мэдрэлийн саа
- B. Шууны урт мэдрэлийн саа
- C. Нугасны гэмтэл (C 7)
- D. Бугалганы хугарал
- E. Мөрний гэмтлийн мэс заслын дараа

/227./ Чихрийн шижингээс урьдчилан сэргийлэх дараах аргуудаас аль нь хамгийн оновчгүй арга вэ?

- A. Зохисгүй хооллолтыг өөрчлөх
- B. Хөл нүцгэн алхах
- C. Илүүдэл жинг бууруулах
- D. Хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх
- E. Амьдралын хэв маягийг өөрчилж эрүүлжүүлэх

/228./ GMFCS I түвшний ерөнхий зарчмыг сонгоно уу?

- A. Бэрхшээлтэй алхана
- B. Туслах хэрэгсэлтэй алхана
- C. Суугаагаас босох
- D. Бэрхшээлгүй алхана
- E. Гүйж чадна

/229./ Уушигны архаг бөглөрөлт өвчний үед ихэвчлэн аль булчингийн сулрал илүүтэйгээр үүсэх вэ?

- A. Дээд мөчний булчин
- B. Цээжний булчин
- C. Хэвлийн булчин
- D. 4 толгойт булчин
- E. 2 толгойт булчин

/230./ 84 настай эмэгтэй. 2 жилийн өмнө зүүн гарын долоовор болон эрхий хурууны мэдрэхүй аажмаар буурсан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд хүндрэл гарсан. Зүүн гаранд ямар төрлийн чигийг хэрэглэх вэ?

- A. Шууны булчингийн чиг
- B. Үений эсэргүүцэлтэй чиг
- C. Тохойны чиг
- D. эргүүлж нугалдаг чиг
- E. Өргөгчтэй чиг

/231./ GMFCS II түвшинд байгаа тархины саажилттай 2 хүртэл насны хүүхдийн хийж чадах үйлдлийг сонгоно уу

- A. Сууж чадна
- B. Мөлхөж чадна
- C. Алхаж чадна
- D. Дэмжлэгтэйгээр сууж чадна
- E. Дэмжлэгтэйгээр суух

/232./ Үйлчлүүлэгч Жанчивт хөдөлмөр засалч эхлээд ямар тусламж үзүүлж болох вэ?

- A. Усанд оруулах
- B. Хөлийн иллэг хийх
- C. Оймс өмсөгч хэрэглэхийг зааж зөвлөх
- D. Тэргэнцэр тохируулж өгөх
- E. Гэрийн үнэлгээ хийх

/233./ Дараах нугасны гэмтлийн түвшинг тохируулна уу.

1. Түнх нугалах A. L2 түвшинд
2. Өвдөг тэнийлгэгч B. L3 түвшинд
3. Тавхай ээтийлгэгч C. L4 түвшинд

4. Эрхий хуруу ээтийлгэгч D. L5 түвшинд

5. Тавхай тэнийлгэгч E.S1 түвшинд

A. A1 B2 D3 E4 C5

B. A1 D2 C3 B4 E5

C. A1 E2 C3 D4 B5

D. A1 B2 C3 D4 E5

E. A1 C2 D3 E4 B5

/234./ GMFCS III түвшинд байгаа тархины саажилттай 2-4 насны хүүхдийн хийж чадах үйлдлийг сонгоно уу

A. Тогтвортой сууж чадна

B. Суух үед түнхний үеэр дотогш эргүүлсэн байрлалтай сууна

C. Суух үед түнхний үеэр гадагш эргүүлсэн байрлалтай сууна

D. Суугаа байрлалаас юм барьж чадна

E. Суугаа байрлалаас юм түшиж босох

/235./ Доод мөчинд үүссэн тэнийлгэх хэлбэрийн нийлмэл хөдөлгөөний үед шагайн үеэр ямар хөдөлгөөнийг хийх вэ?

A. Ээтийлгэх

B. Жийх

C. Тавхай дотогш эргэлт дэхь ээтийлгэх хөдөлгөөн

D. Тавхай гадагш эргэлт дэхь ээтийлгэх хөдөлгөөн

E. Инверси

/236./ Дараах булчингуудаас алийг нь хэвтээ байрлалд үзэх вэ?

A. Гуяны арын 2 толгойт булчин (Biceps brachi)

B. Багана нурууны 2 талын булчин (Semispinalis)

C. Урд шүдэт булчин (Serratus anterior)

D. Дагзны урд шулуун булчин (Rectus capitis anterior)

E. Хонин сүүлт булчин (Deltoid)

/237./ BADS үнэлгээнд байдаггүй хэсгийг олно уу?

A. Түлхүүр олох дасгал

B. Дээд, доод мөчний дасгал

C. Цаг заах дасгал

D. үйлдэл төлөвлөх дасгал

E. Амьтаны зураг олох дасгал

/238./ Б 38 настай эрэгтэй. Мотоцикийн ослоос болж нугасны гэмтэл авсан. Сээр нурууны T12-оос доош булчингийн хүч, гарны булчингийн хүч 5, хөлний булчингийн хүч 0. Анусны рефлекс үлдсэн. Энэ үйлчлүүлэгч ASIA-гийн үнэлгээний аль ангилалд багтах вэ?

A. A

B. B

C. C

D. D

E. E

/239./ Чихрийн шижин өвчний хэдэн хэв шинж байдаг вэ?

A. 2

B. 3

C. 4

D. 5

E. 6

/240./ Чихрийн шижингийн улмаас мөчөө тайруулсан үйлчлүүлэгчид хөдөлмөр засалчийн үзүүлэх тусламжийг нэрлэнэ үү

A. Хагалгааны дараах өвдөлтийн менежментийн талаар сургах

B. Сэргээн засах зорилго, арга стратегийг тодорхойлох

C. Өөрчлөгдсөн биеийн бүтэц, үйл ажиллагаанд дасан зохицоход сургах

D. Суга таяг хэрэглэж чаддаг болоход сургах

E. Цусны шинжилгээгээр глюкозын хэмжээг байнга хянах

/241./ Бартелийн индексийн үндсэн заавраар ADL үнэлэхэд юуг хамруулах вэ?

- A. Цай зөөх
- B. Хоол хийх
- C. Машин барих
- D. Шатаар өгсөж уруудах
- E. Худалдаа хийх

/242./ Паркинсон өвчний дараах шинж тэмдэгүүдээс аль нь тархи судасны паркинсон вэ?

- A. Хөдөлгөөнгүй
- B. Агшилттай
- C. Завсарлагатай салганалт
- D. Пирамидын замын эмгэг
- E. Миерсонгийн чимээ

/243./ Протезын алхааны хүндрэл, шалтгааныг тохируулна уу.

1. Өсгий газар хүрэх (heel strike) фазын дараа өвдөгний нугалах хөдөлгөөн хязгаарлагдах
 2. Stance фазын үед өвдөг хэт тэнийх
 3. Өсгийг газраас хөндийрүүлэх фаз хязгаарлагдах
 4. Шилбэ ясны урд хэсэгт ачаалал ирэх
 5. Stance фазын төгсгөлд өлмий унжих
- A. Өсгийн хэсэг хэт зөөлөн байх
 - B. Өсгий жийх хэлбэр давамгайлсан байх
 - C. Өсгий хэт хатуу байх
 - D. Өлмий хэт ээтийлгэх хэлбэртэй байх
 - E. Хөлний доод хэсэг хэт зөөлөн байх

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A1 B2 C3 E4 D5
- C. A1 B2 E3 D4 C5
- D. A1 C2 D3 E4 B5
- E. A1 D2 E3 C4 B5

/244./ Чихрийн шижингийн улмаас хараагүй болсон үйлчлүүлэгчид хөдөлмөр засалч ямар тусламж үзүүлэх вэ?

- A. Алдагдсан чадварыг нөхөн орлуулах арга барилуудыг зааж сургана
- B. Гадуур гарахад нь тэргэнцрээр үйлчилнэ
- C. Өдөр тутмын хоолоо бэлтгэх, хооллоход нь тусална
- D. Хувийн ариун цэвэр сахихад нь тусална
- E. Нийгмийн харилцааг сайжруулах техник хэрэгслээр хангана

/245./ Алганы ороомог хэлбэрийн чигийг ямар эмгэгийн үед хэрэглэх вэ?

- A. Хүзүү мөр-гарны хам шинж
- B. Тохойны сувгийн хам шинж
- C. Гадна булчингийн хам шинж
- D. сарвууны сувгийн хам шинж
- E. Дотогш эргүүлэх булчингийн хам шинж

/246./ Дээд мөчдийн тайралтын сэргээн засахын үе шатыг уялдуулна уу.

- | | |
|---------------------------------------|------------|
| 1. Ампутаци хийлгэхийн өмнөх зөвлөгөө | A. 1-р үе |
| 2. Ампутаци хийлгэсний дараах хурц үе | B. 2-р үе |
| 3. Протезийн өмнөх үеийн бэлтгэл | C. 3-р үе |
| 4. Протез зүүх бэлтгэл, дасгал | D. 4 –р үе |
| 5. Удаан хугацааны эмчилгээ | E. 5-р үе |

- A. A1 B2 D3 E4 C5
- B. A1 B2 C3 D4 E5
- C. A1 B2 C3 E4 D5
- D. A1 B2 D3 C4 E5
- E. A1 C2 B3 E4 D5

/247./ GMFCS II түвшинд байгаа тархины саажилттай 4-6 насны хүүхдийн хийж чадах үйлдлийг сонгоно уу

- A. Тогтвортой сууж чадна
- B. Суугаа байдлаас босч зогсож чадна
- C. Гадаа алхаж чадна
- D. Суугаа байрлалаас тоглоомоор тоглох
- E. Гүйж чадна

/248./ Жанчив, 70 настай, эрэгтэй. 30 настайдаа Чихрийн шижин хэв шинж-2 өвчнөөр оношлогдсон. 40 гаруй настайдаа эхнэрээсээ салж түүнээс хойш ганцаараа амьдарсаар ирсэн. Чихрийн шижин өвчний учир хоолны дэглэм барих талаар эмч нь байнга зөвлөдөг хэдий ч “тэгэж төвөг удаад хэрэггүй” гэж үзэн мах, гурил голлосон тослог ихтэй хоол хэрэглэдэг. Цусны сахар буулгах эмээ санасан үедээ хэрэглэж хааяа цусны шинжилгээ хийлгэдэг. Нүдний хараа нь муудаад нэлээд хэдэн жил болж байгаа. Одоогийн байдлаар хөлийн хумс нь шигдэж ургаснаас болж хувилж шархалсан учир өрхийн эмч, сувилагчийн тогтмол хяналтанд эмчлүүлж байгаа. Сүүлийн нэлээд хэдэн жил хөл тавхайн мэдрэмж нь муудсан тул хөлөнд үүссэн шархыг мэдэхгүй удаасан байв. Түүний гол зовиур нь хөл өвдсөнөөс болж гадаа гарч хөршүүдтэйгээ даалуу тоглож чадахаа байсан гэж байв. Үйлчлүүлэгч Жанчивт дараах хүндрэлүүдийн аль байх магадлалтай вэ?

1. Цус харвалт
2. Ретинопати
3. Нефропати
4. Нейропати
5. Хөл тайруулах

/249./ Нугасны чухал үйл ажиллагааг сонгоно уу?

1. Хөдөлгөөний мэдээллийг дамжуулах
2. Мэдрэхүйн дамжуулалт
3. Рефлексийн төвийн координаци
4. Мэдээллийг боловсруулах
5. Хамгаалах

/250./ Чихрийн шижингийн үеийн том судасны хүндрэлүүдийг нэрлэнэ үү

1. Сохрох
2. Бөөрний дутагдалд орох
3. Хөл тайруулах
4. Цус харвалт
5. Элэгний цирроз

/251./ Brunnstrom-д хамаарах ухагдахуун?

1. Facilitation(идэвхжүүлэх)
2. Нийлмэл хөдөлгөөн
3. Placing (мөчдийг байршуулах)
4. Хамсал хөдөлгөөн
5. Handling (тодорхой чигт байрлуулах)

/252./ Чихрийн шижинтэй үйлчлүүлэгчтэй хөдөлмөр засалчийн ажиллах чиглэлүүдийг нэрлэнэ үү

1. Өөрийн халамж асаргааны хөдөлмөрүүд
2. Цусан дахь глюкозын хэмжээг хянахад сургах
3. Эм тогтмол хэрэглэх арга барилд сургах
4. Гэрийн ажлаа хийх, чөлөөт цагаа өнгөрөөх талаар
5. Хүндрэлтэй үйлдлүүдийг хийхэд туслах хэрэгсэл ашиглах

/253./ Лигаментийн гэмтлийг илэрхийлэх шинжийг сонгоно уу?

1. Хавдах (ихэнхдээ цаг хагасын дараа илрэнэ)
2. Чихэнд дуу сонсдох (урагдах, тасрах)
3. Үений тогтвортой байдал алдагдах
4. Өвдөлт
5. Хөдөлгөөн хязгаарлагдах

/254./ Нугасны гэмтлийн түвшингийн ангилалыг сонгоно уу?

1. Гэмтлийн түвшин ууцны S4-S5. Мэдрэхүй болон хөдөлгөөний үйл ажиллагаа бүрэн алдагдсан.

2. Гэмтлийн түвшин ууцны S4-S5, болон мэдрэлжүүлэлтийн түвшингээс доош хөдөлгөөний үйл ажиллагаа алдагдсан, мэдрэхүйн үйл ажиллагаа хэвийн.

3. Хөдөлгөөний үйл алдагдаагүй. Мэдрэлжүүлэлтийн түвшингээс доош булчингийн хүч нь 3 болон түүнээс доош, хөдөлгөөний далайц бүрэн

4. Хөдөлгөөний үйл алдагдаагүй: Мэдрэлжүүлэлтийн түвшингээс доош булчингийн хүч нь 3 болон түүнээс дээш

5. Мэдрэл болон нугасны гэмтэлтэй хэдий боловч хөдөлгөөний болон мэдрэхүйн үйл ажиллагаа хэвийн.

/255./ Чихрийн шижинтэй хүмүүст хөдөлмөр засалч ямар үйлчилгээ үзүүлэх вэ?

1. Цусан дахь глюкозын хэмжээг хянах
2. Хоолны дэглэмд хяналт тавих
3. Биеийн ариун цэврийг сахиулах
4. Өдөр тутмын үйл ажиллагаандаа оролцох боломжийг олгох
5. Дасгал зааж өгч хөдөлгөөний идэвхтэй болгох

/256./ Чихрийн шижингийн үеийн жижиг судасны хүндрэлүүдийг нэрлэнэ үү

1. Ретинопати
2. Нейропати
3. Нефропати
4. зүрхний шигдээс
5. тархинын цус харвалт

/257./ Хөдөлмөр засалч нь ахмад настанд юугаар тусладаг вэ?

1. Ахмад настай хүний бие бялдарт гарах аливаа өөрчлөлтийг даван туулж өдөр тутмын амьдралдаа бие даан оролцох боломжийг бий болгоход

2. Аливаа гэмтэл, өвчний дараах сэтгэлзүй болон нийгмийн зохицуулалтанд

3. Ахмад настны үйл ажиллагааг хялбар аюулгүй байлгах үүднээс тухайн хүнд тохируулан гэрийн орчныг өөрчлөхөд зөвлөнө

4. Зарим нэг шаардалагатай туслах хэрэгслийг ашиглаж сурахад тусалдаг

5. Усанд орох, бие засах гэх мэт хувийн ариун цэвэр сахихад тусална

/258./ Ампутаци хийгдсэн бугалганы уртыг ямар түвшингөөс хэмжих вэ?

1. Далны шонтон
2. Суганы түвшин
3. Мухар төгсөлийн гадна ирмэг
4. Мухар төгсгөл
5. Далны шонтонгийн өмнөд төвгөр

/259./ Чихрийн шижингийн өөрчилж болох эрсдэлт хүчин зүйлсэд аль нь орох вэ?

1. Нас
2. Илүүдэл жин, хөдөлгөөний хомсдол
3. Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлт
4. Зохисгүй хооллолт, архи хэтрүүлэн хэрэглэх
5. Удамшил

/260./ Гарны үйл ажиллагааны өвөрмөц тест (STEF) зөв хариултуудыг олно уу?

1. 8 хэсгээс бүрдэнэ
2. Стандарт үнэлгээ
3. Баруун зүүн талд тус бүрдээ 50 оноо авна
4. Хэсэг тус бүрийн оноонуудыг нэмнэ
5. Харвалттай үйлчлүүлэгчийн гарны үйл ажиллагааг сайжруулна.

/261./ Үйлчлүүлэгч Жанчивт дараах хүндрэлүүдийн аль байх магадлалтай вэ?

1. Цус харвалт
2. Ретинопати
3. Нефропати
4. Нейропати
5. Хөл тайруулах

/262./ Чихрийн шижинтэй хүнд хөдөлмөр засалч ямар үнэлгээ, шинжилгээг хийх вэ?

1. Цусан дахь глюкоз тодорхойлох
2. Хүрэлцэх мэдрэхүйн алдагдлыг тодорхойлох
3. Биеийн жингийн индекс тодорхойлох

4. Хүсэл сонирхлын шалгах хуудас ашиглах

5. Цусны даралт хэмжих

/263./ GMFCS III түвшинд байгаа тархины саажилттай 2-4 насны хүүхдийн хийж чадах үйлдлийг сонгоно уу?

1. Тогтвортой сууж чадна

2. Суух үед түнхний үеэр гадагш эргүүлсэн байрлалтай сууна

3. Суугаа байрлалаас юм барьж чадна

4. Суух үед түнхний үеэр дотогш эргүүлсэн байрлалтай сууна

5. Зогсож чадна

/264./ Мөрний мултралын үед өндөр настай хүмүүст хэрэглэдэг эвийн эмчилгээний аргын нэрийг сонгоно уу.

A. Кохерийн арга

B. Гипократын арга

C. Джанелийн арга

D. Стимсоны арга

E. Монгол арга

/265./ Шагайн үений гэмтлийн үед зонхилон гэмтдэг холбоос аль нь вэ?

A. Anterior talo-fibular ligament

B. Posterior talo-fibular ligament

C. Calcaneo-fibular ligament

D. Mediale deltoideum

E. Anterior cruciate ligament

/266./ Эгэмний яс нь ихэвчлэн ямар хүчний үйлчлэлийн улмаас хугардаг вэ?

A. Шууд гадны хүчний үйлчлэлээс

B. Шууд бус гадны хүчний үйлчлэлээс

C. Мөрөөр тулж унах үед

D. Гараар тулж унасан үед

E. Тохойгоор тулж унасан үед

/267./ Битүү гөлтгөнөн боолтыг тавьсны дараа ямар хүндрэл илүүтэй гарч болох вэ?

A. Холголт

B. Арьсны идэвхгүй бичил биет үхэж, цаашид мөөгөнцөрөөр солигдох

C. Мөч тэжээгч гол судсыг дарж цусгүйжилт үүсэх

D. Мэдрэлийн судлыг дарж неврит үүсгэх

E. Байнгын өвдөлт өгөх

/268./ Шагайн үений зөөлөн эдийн гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжид тохирохгүйг сонгоно уу.

A. Хөдөлгөөнгүй байлгах

B. Хүйтэн жин тавих

C. Даралттай боолт

D. Зүрхний түвшнөөс өндөрлөх

E. Сэргээн засах

/269./ Дараах шууны хугаралуудын нэрийг зөв харгалзуулна уу.

1. Коллесын хугарал

2. Смитийн хугарал

3. Чофер хугарал

4. Дорсал бартон

5. Палмар бартон

A. Бугуйн үенээс хойш 1-3 см зайд доош чиглэлтэй хугарах

B. Шуу ясны толгойн хэсгээр үе дайрсан ташуу хугарал

C. Бугуйн үенээс хойш 1-3 см зайд дээш чиглэлтэй хугарах

D. Шуу ясны дээд өнцөг сэлтэрч дээш чиглэлтэй хугарах

E. Шуу ясны дээд өнцөг сэлтэрч дээш чиглэлтэй хугарах

A. 1.D 2.E 3.A 4.B 5.C

B. 1.C 2.A 3.B 4.D 5.E

C. 1.E 2.A 3.B 4.C 5.D

D. 1.A 2.C 3.B 4.D 5.E

Е. 1.С 2.В 3.А 4.Д 5.Е

/270./ Мөрний үений мултралын дараа үүсдэг гол хүндрэлийг сонгоно уу.

- А. Булчин хатингарших
- В. Банкартын гэмтэл
- С. Үений хөшингө
- Д. Мэдрэхүй алдагдах
- Е. Хаван

/271./ Мөрний үений мултрал зонхилон хаашаа мултардаг вэ?

- А. Дээшээ мултрах
- В. Доошоо мултрах
- С. Арагш мултрах
- Д. Урагш мултрах
- Е. Хажуу мултрал

/272./ Шагайн үений гэмтлийн үед ямар боолтын хэлбэрийг сонговол тохиромжтой вэ?

- А. Ороох хэлбэрийн боолт
- В. Мушгиа хэлбэрийн боолт
- С. Наймын тоо хэлбэрийн боолт
- Д. Холдуулах хэлбэрийн боолт
- Е. Ойртуулах хэлбэрийн боолт

/273./ Мөрний мултралын дараа зонхилон тохиолддог мэдрэлийн судлын гэмтлийг сонгоно уу.

- А. Шууны мэдрэл
- В. Богтосны мэдрэл
- С. Суганы хонхрын мэдрэл
- Д. Дунд мэдрэл
- Е. Далны хамрын доод мэдрэл

/274./ Тохойн үе хэдэн үелэмжээс бүтэх вэ?

- А. Хоёр үелэмж
- В. Гурван үелэмж
- С. Дөрвөн үелэмж
- Д. Таван үелэмж
- Е. Нэг үелэмж

/275./ Коллесийн хугарлын үед эгц хажуугийн байрлалаас харахад өвөрмөц ямар шинж илэрдэг вэ?

- А. Хаван хавдар ихтэй байна
- В. Сэрээ хэлбэрийн өөрчлөлт ажиглагдана
- С. Эмгэг хөдөлгөөн илэрнэ
- Д. Улайсан харагдана
- Е. Хэлбэр дүрс нь өөрчлөгдөнө

/276./ Дараах хугарал мултралуудыг онцлох шинж тэмдэгтэй нь хамааруулна уу.

1. Мөрний мултрал
 2. Эгэмний хугарал
 3. Тохойн мултрал
 4. Бугалганы мэс заслын хүзүүний хугарал
 5. Бугалганы доод булууны хугарал
- А. Хонин сүүлт булчингийн төвгөр арилсан
 - В. Толгойгоороо өвдөж буй талруу гэлжийсэн байх
 - С. Хутерийн гурвалжин өөрчлөгдөнө.
 - Д. Бугалганы урт нь богинсоно.
 - Е. Хутерийн гурвалжин өөрчлөгдөнө.

- А. 1.А 2.В 3.С 4.Д 5.Е
- В. 1.Е 2.В 3.С 4.Д 5.А
- С. 1.А 2.Д 3.С 4.В 5.Е
- Д. 1.В 2.А 3.С 4.Д 5.Е
- Е. 1.А 2.В 3.Е 4.С 5.Д

/277./ Тохойн үений мултрал нь нийт мултралуудын дотроос тохиолдлоороо хэддүгээр байранд ордог вэ?

- A. 1-р байр
- B. 3-р байр
- C. 2-р байр
- D. 4-р байр
- E. 5-р байр

/278./ Мөрний үений мултрал үүсэхэд бүтэцтэй холбоотой шалгааныг сонгоно уу.

- A. Спортын гэмтэл их тохиолддог
- B. Далны тогоо бугалганы толгойноос том
- C. Бугалга ясны толгойтой харьцуулахад далны үений тогоо жижиг
- D. Бүх чиглэлд өргөн хүрээний далайцаар хөдөлдөг
- E. Их биеэс товойж гарсан хэсэг тул гадны нөлөөлд их өртдөг

/279./ Эгэмний хугаралтай хүүхдэд бэхэлгээ боолтыг хэдэн хоног хийх вэ?

- A. 7 хоног
- B. 1-2 долоо хоног
- C. 2-3 долоо хоног
- D. 3-4 долоо хоног
- E. 4-5 долоо хоног

/280./ Бинтэн боолтыг аль хэсэгт хэдэн номерийн боолт хэрэглэгдэхийг сонгоно уу.

1. № 5-7:
2. № 3-4:
3. № 2:
4. № 1:

- A. том хүний толгой, гуя, хүүхдийн цээж, хэвлий, аарцаг
 - B. том хүний мөр болон өвдөгний үе бугалга, хүүхдийн гуя
 - C. хүүхдийн гар хөлийн сарвуу, өсгий, том хүний хуруу 91
 - D. том хүний бугалга, тохойн үе, шуу яс, тавхай, шилбэ, хүүхдийн мөр, өвдөгний үе 92
- A. 1.C 2.D 3.B 4.A
 - B. 1.D 2.C 3.B 4.A
 - C. 1.C 2.D 3.A 4.B
 - D. 1.A 2.D 3.B 4.C
 - E. 1.B 2.D 3.C 4.A

/281./ Хавсарсан гэмтэл гэж юу вэ?

- A. Нэг мөчинд хэд хэдэн хугарал гэмтэл үүсэх
- B. Хоёр ба түүнээс дээш мөч гэмтэх
- C. Хэвлий дотор эрхтэн мөчдийн хугаралтай зэрэг гэмтэх
- D. Яс, шөрмөс, арьс зэрэг гэмтэх
- E. Хэвлий дотор хоёр ба түүнээс дээш эрхтэн гэмтэх

/282./ Шуу ясны хугарлын хамгийн элбэг тохиолддог хугаралыг сонгоно уу?

- A. Смитийн хугарал
- B. Коллесийн хугарал
- C. Бартоны хугарал
- D. Богтос ясны төгсгөлийн цуурал
- E. Шоперийн хугарал

/283./ Коллес хугарлын үед шуу, богтосны рентген зургийг уншихдаа зайлшгүй харах хэмжээсүүдийг зөв уялдуулна уу.

1. Шуу ясны толгойн налуу өнцөг
 2. Шуу, богтосны сэртэн хоорондын зай
 3. Шуу богтосны өндөр хоорондын зай
 4. Шуу богтосны нам хэсгийн хоорондын зай
 5. Шуу ясны хажуу өнцгөөс авсан алга руу чиглэсэн налуу өнцөг
- A. 8-10 мм
 - B. 23 хэм
 - C. ± 2
 - D. 9-12 мм

Е. 11 хэм

- A. 1.B 2.A 3.D 4.E 5.C
- B. 1.B 2.A 3.D 4.C 5.E
- C. 1.A 2.B 3.C 4.D 5.E
- D. 1.A 2.C 3.B 4.E 5.D
- E. 1.B 2.C 3.D 4.E 5.A

/284./ Үений мултралын дотроос хамгийн элбэг хамгийн үе аль нь вэ?

- A. Тохойн үе
- B. Мөрний үе
- C. Шагайн үе
- D. Эрүүний үе
- E. Түнхний үе

/285./ Гэмтлийн дараа олонтаа тохиолддог мултралыг нэрлэнэ үү?

- A. Мөрний үе
- B. Эрүүний үе
- C. Түнхний үе
- D. Тохойн үе
- E. Шагайн үе

/286./ Шагайн үений шагай тахилзуурын өмнөд холбоосын гэмтлийн үед ямар өвөрмөц тестийн аргаар оношлох вэ?

- A. Хазайлгах тест
- B. Anterior drawer sign
- C. Pivot test
- D. Lackman test
- E. Үений далайцын сорил

/287./ Бинтэн боолтыг хийхдээ анхаарах ёстой хэсгийг сонгоно уу.

- A. Өвчтөнөө боолт хийхэд тохиромжтой байдлаар суулгах юмуу хэвтүүлээд боолтоо хийнэ.
- B. Боолтоо хөдөлгөөнгүй тогтвортой байлгахын тулд боолт хийж байгаа үед үе мөчийг физиологийн тайван байрлалд булчинг сул байлгаж бооно.
- C. Тохойн үеийг боохдоо гарын шууг тохойн үеэнд тэгш өнцөг үүсэхээр нугална.
- D. Өвдөгний үеийг боохдоо өвдгийг хагас нугалсан байдалд байлгана.
- E. Бүгд зөв

/288./ Коллесийн хугарлын зонхилох шалтгааныг сонгоно уу.

- A. Гарын алгаар тулж унахад үүснэ
- B. Гараа алдалж унахад үүснэ
- C. Гараа дотогш нугалж унахад үүснэ
- D. Гарын алганы араар тулж унахад үүснэ
- E. Тохойн үеэр тулж унахад үүснэ

/289./ Мөрний мултралын бариа засал хийж оруулсны дараа хэдэн долоо хоног бэхэлгээ боолттой байх вэ?

- A. 1 долоо хоног
- B. 1-2 долоо хоног
- C. 2-3 долоо хоног
- D. 3-4 долоо хоног
- E. 4-5 долоо хоног

/290./ Мөрний мултралын үеийн нөхөн сэргээх эмчилгээний зарчим

- 1. Эхний 7 хоног
- 2. 2 дахь долоо хоног
- 3. 3 дахь долоо хоног
- 4. 4 дэх долоо хоног
- 5. 5 дахь долоо хоног
- A. Хүйтэн жин ихээр тавьна.
- B. Халууны эмчилгээнүүд, гар сарвуу, тохойн үений идэвхитэй хөдөлгөөний дасгал
- C. Кодманы дасгал

- D. Боолтыг авч идэвхитэй дасгал хөдөлгөөныг хийлгэнэ.
E. Дахин мултралаас урьдчилан сэргийлж спортын дасгалуудыг хориглоно

- A. 1.A 2.B 3.C 4.D 5.E
B. 1.E 2.B 3.C 4.D 5.A
C. 1.A 2.D 3.C 4.B 5.E
D. 1.E 2.B 3.C 4.A 5.C
E. 1.A 2.B 3.E 4.C 5.D

/291./ Гэмтлийн нэрийг хийгдэх боолтын төрөлтэй зөв уялдуулна уу.

1. 8 тоо хэлбэрийн боолт
 2. Татлагатай 8 тоо хэлбэрийн боолт
 3. Тариан түрүү хэлбэрийн боолт
 4. Холдуулах хэлбэрийн боолт
 5. Цуулбар боолт
- A. Эгэм ясны хугарал
B. Мөрний үений мултрал
C. Тохойн үений зөөлөн эдийн гэмтэл
D. Эрүүний үений мултрал
E. Шагайн үений зөөлөн эдийн гэмтэл
- A. 1.E 2.A 3.B 4.C 5.D
B. 1.A 2.E 3.B 4.C 5.D
C. 1.E 2.B 3.A 4.C 5.D
D. 1.E 2.A 3.B 4.D 5.C
E. 1.B 2.A 3.E 4.C 5.D

/292./ Төрөх үед хүүхдийн эгэм хугарахад ямар шинж илрэх вэ?

- A. Мөрний үенд цус хурна
B. Хугархайд шаржигнах чимээ гарна
C. Цусан хангамжийн өөрчлөлт гарна
D. Мөчинд саа үүснэ
E. Өлгийдөхөд өвдөлт мэдэрч шалтгаангүйгээр уйлна.

/293./ Ортопедийн шинжлэх ухаан юуг судалдаг вэ?

- A. Булчин шөрмөсний тогтолцоог
B. Яс шөрмөсний тогтолцоог
C. Яс булчингийн тогтолцоог
D. Мэдрэл булчингийн тогтолцоог
E. Шөрмөс холбоосын тогтолцоог

/294./ Шагайн үений булгаралын үед илрэх шинж тэмдэг аль нь вэ?

- A. Өвдөлт
B. Хавдалт
C. Алхаа гишгээний өөрчлөлт:
D. Арьсан дорх цус шүүрэлт
E. Бүгд зөв

/295./ Гэмтлийн дараах мөрний мултралын үед илрэх шинж тэмгээс тохирохгүйг сонгоно уу.

- A. Мөрний үе ойролцоогоор 30°гадагш тахийж, улмаар бугалганы шугам бага зэрэг гадагш эргэж, биед ойртсон байдалтай байна.
B. Хонины сүүл булчин багасч, далны том сэртэн өнцөг гарган товойно.
C. Далны том сэртэнгийн доод хэсэг хоосорно. (бугалганы толгойн байрлалын гажиг)
D. Бага зэрэг гадагш тахийсан бугалгыг цээж рүү ойртуулаад гараа холдуулахад буцаад хэвэндээ орно

- E. Бага зэрэг гадагш тахийсан бугалгыг цээж рүү ойртуулж, холдуулахад чөлөөтэй хөдөлнө

/296./ Шуу ясны хугарлуудыг хэдэн хэмд аль хугарал үүсэхийг зөв тохируулна уу.

1. Галецийн хугарал
2. Коллес хугарал
3. Сарвууны ясны хугарал
4. Смитийн хугарал
5. Завь хэлбэрийн ясны хугарал

- A. 0~40°
- B. 90°-с дээш
- C. 40~90°
- D. 90°-с дээш
- E. 40~90°

- A. 1.A 2.C 3.B 4.E 5.D
- B. 1.C 2.A 3.B 4.E 5.D
- C. 1.D 2.C 3.B 4.E 5.A
- D. 1.E 2.C 3.B 4.A 5.D
- E. 1.B 2.C 3.A 4.E 5.D

/297./ Мөрний үений мултралын үед ямар боолтын хэлбэрийг сонговол тохиромжтой вэ?

- A. Ороох хэлбэрийн боолт
- B. Тариан түрүү хэлбэрийн боолт
- C. Наймын тоо хэлбэрийн боолт
- D. Холдуулах хэлбэрийн боолт
- E. Ойртуулах хэлбэрийн боолт

/298./ Мөрний урагш мултралыг оруулах аргуудыг зөв уялдуулна уу.

1. Кохерийн арга, гиппократын арга, стимсоны арга
2. Де Палмагийн арга
3. Хөндлөн татах арга

- A. Арагш мултрал
- B. Доошоо мултрал
- C. Урагш мултрал

- A. 1.C 2.A 3.B
- B. 1.A 2.B 3.C
- C. 1.A 2.B 3.C
- D. 1.C 2.B 3.A
- E. 1.A 2.C 3.B

/299./ Эгэмний ясны хугарлын дараах шинж тэмдэгт тохирохгүйг сонгоно уу.

- A. Өвдөлт
- B. Мөрөөр чөлөөтэй хөдлөнө
- C. Ясны хавирах чимээ
- D. Эмгэг хөдөлгөөн
- E. Мөр богиноссон

/300./ Тохойн үе зонхилон хаашаа мултардаг вэ?

- A. Урагш мултрах
- B. Дээшээ мултрах
- C. Хажуу тийш мултрах
- D. Арагш мултрах
- E. Хугарал, мултрал хавсрах

/301./ Чангалуур боолт тавих хугацааг заана уу?

- A. Зун 2 цаг, өвөл 1 цаг
- B. Зун 1 цаг, өвөлд 2 цаг
- C. Өвөл зунд адилхан 2 цаг
- D. Зун 1,5 цаг өвөл 30 мин
- E. Жилийн аль ч улиралд 30 мин

/302./ Мөрний үений мултрал үүсэхэд үйл ажиллагаатай холбоотой шалгааныг сонгоно уу.

- A. Спортын гэмтэл их тохиолддог
- B. Далны тогоо бугалганы толгойноос том
- C. Бугалга ясны толгойтой харьцуулахад далны үений тогоо жижиг
- D. Бүх чиглэлд өргөн хүрээний далайцаар хөдөлдөг
- E. Их биеэс товойж гарсан хэсэг тул гадны нөлөөлд их өртдөг

/303./ Эгэм яс хугарахад гарах хүндрэл

- A. Суганы артери гэмтэх
- B. Мөрний сүлжээ гэмтэх
- C. Гүрээний артери дарагдах

D. Тэнэгч мэдрэл дарагдах

E. N.radialis гэмтэх

/304./ Боолтыг хийх зорилгод тохирохгүйг сонгоно уу.

A. Хугарал, мултрал гэмтлийн үед гэмтсэн хэсгийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж хөдөлгөөнгүй болгох.

B. Бактерийн халдвар ба гэмтлээс гарах шарх зэргээс хамгаалах.

C. Цус алдаж байгаа хэсгийг шахаж чангалснаар цус алдалтыг тогтоох

D. Хугарсан мөчний байрлалыг хадгалж татаж боох

E. Гэмтсэн мөчний хөдөлгөөнийг эвтэйхэн болгох

/305./ Коллесийн хугарал үүсэх зөв байршлыг сонгоно уу.

A. Бугуйн үений гадаргаас 3-4 см зайд

B. Бугуйн үений гадаргаас 1-2 см зайд

C. Бугуйн үений гадаргаас 1-3 см зайд

D. Бугуйн үений гадаргаас 4-5 см зайд

E. Бугуйн үений гадаргаас 5-6 см зайд

/306./ Мөрний үений мултралыг бариа заслын аргаар эмчлэхийн өмнө шалгах зүйлд алдаатайг сонгоно уу.

A. Цусан хангамж

B. Мэдрэхүй

C. Хөдөлгөөн

D. Бэхэлгээ материал бэлтгэх

E. Тайван байлгаж, гүнзгий амьсгалуулах

/307./ Дараах мөрний хөдөлгөөний чиглэлүүдийг булчингуудтай нь уялдуулан сонгоно уу.

1. Мөрний үеэр нугалах

2. Мөрний үеэр тэнийлгэх

3. Мөрний үеэр холдуулах

4. Мөрний үеэр гадагш эргүүлэх

5. Мөрний үеэр ойртуулах

A. Далны хамрын дээд булчин, бага бөөрөнхий булчин

B. Хонин сүүлт булчингийн хойд хэсэг, далбайн булчин, том бөөрөнхий булчин

C. Хонин сүүлт булчингийн дунд хэсэг, далны хамрын дээд булчин

D. Цээжний том хөх мах, том бөөрөнхий булчин

E. Хонин сүүлт булчингийн урд хэсэг, цээжний хөх махны эгэмний салаа

A. 1.A 2.B 3.C 4.D 5.E

B. 1.E 2.B 3.C 4.D 5.A

C. 1.A 2.D 3.C 4.B 5.E

D. 1.E 2.B 3.C 4.A 5.C

E. 1.A 2.B 3.E 4.C 5.D

/308./ Тохойн үений арагш мултралын үед илрэх шинж тэмдгээс тохирохгүйг нь сонгоно уу.

A. Тохойн үеэр 30-45 өнцөг нугаларсан байрлалтай

B. Шуу богиноссон байна мэт харагдана

C. Гурван толгойт булчингийн шөрмөс татагдаж хоёр талаар хонхойхгүй

D. Үений хэсгээх хавантай

E. Тохойн хөдөлгөөн хязгаарлагдана

/309./ Бугалганы мэс заслын хүзүүний хугарлын үед дотуур цус алдалтын улмаас хонины сүүл булчин хавдах ба бугалганы дээд болон цээжний хэсгээр хөхрөлт үүснэ.

/310./ Тохойн үений арагш мултрал нь гараар тулж унахад үүсдэггүй бөгөөд дээд мөчдийн хөдөлгөөн чөлөөтэй, булчингийн хүчдэл ердийн байна.

/311./ Хүүхдийн өсөлтийн хэсгийн хугарлыг оношлоход ихээхэн төвөгтэй ба яаралтай мэс засал хийх шаардлагатай байдаг.

/312./ Мөрний үе нь хамгийн их мултардаг үе бөгөөд бугалганы толгой, далны тогооны хонхор хоёрын харьцаа алдагдсан байдагтай холбоотой юм.

/313./ Эгэмний яс нь гадны шууд бус хүчний нөлөөнөөс үүсэх нь их байдаг бөгөөд хүүхдийн яс бүрэн гүйцэд бэхжээгүй байдаг тул хугарал нь эдгэхдээ хурдан.

/314./ Мөрний үений урагш мултралын үед мөрний үе ойролцоогоор 30° гадагш тахийж, улмаар бугалганы шугам бага зэрэг гадагш эргэж, биед ойртсон байдалтай, хонин сүүл булчин багасч, далны том сэртэн өнцөг гарган товойн гардаг учраас кохерийн аргыг ашиглан бариа засал хийх шаардлагатай.

/315./ Коллесийн хугаралын үед гаднаас харахад сэрээ хэлбэр, жад хэлбэрийн өөрчлөлтүүд гардаг бөгөөд бариа засал эмчилгээ хийхээс өмнө цусны судасны эргэлт, мэдрэхүй, хөдөлгөөн зэргийг заавал шалгах ёстой.

/316./ Бугалганы мэс заслын хүзүүний хугарал нь нас ахих тусам түүний хувь өсч, эрсдэл нэмэгдэж байдаг ба эвийн аргаар эмчлэх үед 2-3 долоо хоног гипстэй байлгана.

/317./ Доош мултрал нь суганы хонхор дахь мултрал бөгөөд өвчтөн гараа биедээ наасан гэмтэлтэй тал руу хазайсан байдалтай ирдэг.

/318./ Эрхий хурууны мултралыг таньж оношлоход хялбар байдаг бөгөөд мултралын үед эрхий хуруу угийн үеэрээ арагшаа сууж, нэгдүгээр үеэрээ урагш нугарсан байна.

/319./ Далайцаараа гүйцэд хөдөлсөнөөр хүн өөрийн хүссэн, зорилгот хөдөлгөөнийг хийх чадвартай болгодог дасгалыг нэрлэнэ үү?

- A. Усан доторх дасгал
- B. Үений далайцын дасгал
- C. Булчингийн хүч хөгжүүлэх дасгал
- D. Уян хатны сунгалтын дасгал
- E. Аэробек дасгал

/320./ Дараах үений хөдөлгөөнийг үений далайцтай уялдуулна уу.

- A. Өвдөг нугалах
- B. Өвдөг тэнийлгэх
- C. Шагай нугалах
- D. Шагай тэнийлгэх
- E. Тавхай дотогш эргүүлэх

1. 0-135

2. 0

3. 0-20

4. 0-50

5. 0-35

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A2 B3 C4 D5 E1
- C. A3 B4 C5 D1 E2
- D. A4 B5 C1 D2 E3
- E. A5 B1 C2 D3 E4

/321./ Дулааны эмчилгээнд аль нь орох вэ?

- A. Рашаан эмчилгээ
- B. Тосон эмчилгээ
- C. Усан эмчилгээ
- D. Солюкс эмчилгээ
- E. Гэрэл эмчилгээ

/322./ Алдагдсан чадварыг үнэлэн, явах чадварыг заан, эзэмшүүлж, хөл болон цээжний хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлэх тэдгээрийн хүч, тэсвэр, координацийг хөгжүүлэх дасгал хийлгэхээс гадна физик эмчилгээний багаж төхөөрөмжийг хэн ажиллуулдаг вэ?

- A. Хөдөлгөөн засалч
 - B. Хөдөлмөр засалч
 - C. Хэл засалч
 - D. Сувилагч
 - E. Сэргээн засахын эмч
- /323./ Үений далайцыг ямар багажаар хэмждэг вэ?
- A. MMT
 - B. ROM
 - C. Гониометр
 - D. Электромиограмм
 - E. Электрокардиограмм
- /324./ Амьсгалын дасгалын дүнд өрц амьсгалд идэвхитэй оролцон амьсгалахад зарцуулагдах энерги багасч, . . . -ийн хангамж ихсэж, хийн солилцоо нэмэгдэж, өвчтний ачаалал тэсвэрлэх чадавхи дээшилдэг
- A. O₂
 - B. CO₂
 - C. NO₂
 - D. SO₂
 - E. O
- /325./ Амьсгалын төвийн үйл ажиллагааг сайжруулах эмчилгээг сонгоно уу?
- A. Франклизаци эмчилгээ
 - B. Диадинамик эмчилгээ
 - C. Амплипульс эмчилгээ
 - D. Электрофорез эмчилгээ
 - E. УВЧ эмчилгээ
- /326./ Сэргээн засах эмчилгээг ямар зорилгоор хийдэг вэ?
- A. Өвчин, эмгэгийг эмчлэх
 - B. Гэмтэлээс сэргийлэх
 - C. Хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх, эмчлэх
 - D. Үйл ажиллагааны чадварыг сайжруулах, тогтворжуулах
 - E. Үйл ажиллагааны чадварыг бууруулах
- /327./ Мөрний үений хөдөлгөөнийг үений далайцтай уялдуулна уу.
- A. Нугалах
 - B. Тэнийлгэх
 - C. Холдуулах
 - D. Ойртуулах
 - E. Гадагшлуулах
1. 0-180
 2. 0-60
 3. 0-180
 4. 0-45
 5. 0-90
- A. A1 B2 C3 D4 E5
 - B. A2 B3 C4 D5 E1
 - C. A3 B4 C5 D1 E2
 - D. A4 B5 C1 D2 E3
 - E. A5 B1 C2 D3 E4
- /328./ Сэргээн засах эмчилгээ нь ямар эмчилгээ, үйлчилгээг үзүүлдэг вэ?
- A. Дасгал хөдөлгөөн
 - B. Физик эмчилгээ
 - C. Бариа засал
 - D. Олон төрлийн эмчилгээ
 - E. Зүү эмчилгээ
- /329./ Сэргээн засах эмчилгээг хэзээнээс эхэлж хийж эхлэх вэ?
- A. Өвчин эхэлсэнээс хойш 2 жилийн дараа
 - B. Өвчин эхэлсэнээс хойш 3 сарын дараа

C. Өвчин эхэлсэнээс хойш 6 сарын дараа
D. Өвчтөний өвдөж эхэлсэн цагаас
E. Эмчлэгч эмчийн зааврын дагуу
